



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А1160

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 29 дүгээр зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 5 дахь хэсгийн 5.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрдмэл магадлал зохион байгуулах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга /П.Мөнхтулга/-т, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга /Г.Саран/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.ЗОРИГТ

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын даргын 2017 оны
1.0 дүгээр сарын 18-ны өдрийн
А116.0 тоот тушаалын хавсралт



ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ТӨВ КОМИССЫН БҮРДМЭЛ МАГАДЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

1. Зорилго

- 1.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /цаашид "Төв комисс" гэх/ нь орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, иргэдэд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон болон хөдөлмөр зохицуулалт хийсэн байдалд бүрэн бүрэлдэхүүнээр магадлал хийх зорилготой.

2. Хамрах хүрээ

- 2.1. Бүрдмэл магадлалын үйл ажиллагааг Нийгмийн даатгалын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 28, 29 дүгээр зүйл, Засгийн газрын тогтоолоор баталсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм" болон бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулна.
- 2.2. Бүрдмэл магадлалыг аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо, улсын дунджаас өндөр байгаа тохиолдол, сүүлийн 3 жилийн тайланд хийсэн дүн шинжилгээ, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын байдлыг үндэслэн сонгоно.
- 2.3. Бүрдмэл магадлалыг иргэдийн үзлэг оношилгоо болон бичиг баримтын үзлэг гэж хоёр ангилан зохион байгуулна.
- 2.4. Тухайн орон нутгийн хөдөлмөрийн чадвар алдагсадын 50 хүртэл хувийг хамруулах бөгөөд үүний 25%-иас доошгүй иргэнийг байлцуулж бүрдмэл магадлал хийнэ.
- 2.5. Бичиг баримтын магадлалд хамрагдах иргэдийг орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тайланд хийсэн дүн шинжилгээг үндэслэн сонгоно.
- 2.6. Аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс Төв комисст бүрдмэл магадлал хийлгэх хүсэлтийн дагуу зохион байгуулж болно.
- 2.7. Төв комисс нь жилийн болон улирлын төлөвлөгөөнд бүрдмэл магадлал зохион байгуулах аймаг (дүүрэг) болон хийх хугацааг зааж тусгасан байна.
- 2.8. Бүрдмэл магадлалын үйл ажиллагаа явуулах төсөв, удирдамжийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

3. Бүрдмэл магадлал хийх бүрэлдэхүүн

- 3.1. Бүрдмэл магадлалыг Төв комиссын дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч нар болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, гишүүдийг оролцуулан зохион байгуулна.
- 3.2. Төв комиссын бүрдмэл магадлал явуулах багийн бүрэлдэхүүнийг тухайн орон нутагт хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан, өвчлөлийн байдал зэргээс хамааран сонгоно.
- 3.3. Бүрдмэл магадлалын хурлын үед илүү цагаар ажиллаж болох ба цагийн хөлсийг ажилласан цагаар тооцон олгох бөгөөд нийт бүрэлдэхүүний томилолтын зардлыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага хариуцна.

4. Бүрдмэл магадлалын үе шат

4.1. Бэлтгэл үе


- 4.1.1. Төв комисс нь мэдээллийн баазаас бүрдмэл магадлалд хамруулах иргэдийн нэрсийг зорилтот түүвэрлэлтийн аргаар бэлтгэн 21 хоногийн өмнө орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагч эмчид илгээнэ.
- 4.1.2. Бүрдмэл магадлалыг зохион байгуулах дараахь бэлтгэл ажлыг орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс хариуцна. Үүнд:

- ✓ үзлэгийн хуваарь гаргах;
- ✓ үзлэгийн өрөө бэлтгэх;
- ✓ шаардлагатай шинжилгээ оношилгооны тоног төхөөрөмжөөр хангах;
- ✓ бүрдмэл магадлалын жагсаалтад нэр нь орсон иргэд даатгуулагчдыг хуваарийн дагуу оролцуулах;
- ✓ шаардлагатай тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагаас эмч, мэргэжилтнийг ажиллуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 4.1.3. Зохион байгуулалтын арга хэмжээнээс шалтгаалан иргэдийг бүрдмэл магадлалд хангалтгүй хамруулсан бол Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллана.
- 4.1.4. Хүндэтгэх шалтгаангүйгээр бүрдмэл магадлалд хамрагдаагүй иргэд даатгуулагчдыг Төв комиссын дахин магадлалд хамруулсны дараа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг үргэлжлүүлэн сунгана.

4.2. Бүрдмэл магадлал хийх үе

- 4.2.1 Бүрдмэл магадлалыг Төв комиссын дарга удирдах бөгөөд нарийн бичгийн даргаар комиссын нарийн бичгийн дарга эсхүл магадлагч эмч ажиллана.
- 4.2.2 Бүрдмэл магадлалын хурал нь орон нутгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлалын хурлын нэгэн адил зохион байгуулалттай байна.



- 4.2.3 Иргэдийг хуваарийн дагуу бүртгэн хүлээн авч үзлэг хийж, оношийн үндэслэлийг нягтлан, хөдөлмөрийн чадвар бүрэн буюу хэсэгчилэн алдсан байдал, шалтгаан хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох асуудалд дахин магадлал хийн хамтын шийдвэр гаргана.
- 4.2.4 Бичиг баримтын дахин магадлалыг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн амбулаторийн картан дахь хийгдсэн эмчилгээ, шинжилгээ, оношилгоо, эмчлэгч эмчийн бичсэн дүгнэлт, эмнэлэг хяналтын комиссын шийдвэр, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байдал зэргийг үндэслэн хийнэ.
- 4.2.5 Бүрдмэл магадлал зохион байгуулах хугацаанд Төв комисс болон Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд ажлын байрны сургалт зохион байгуулж болно.

5. Бүрдмэл магадлалын үр дүн баталгаажилт

- 5.1. Бүрдмэл магадлалын шийдвэрийг Төв комиссын шийдвэрийн хэвлэмэл хуудсан дээр хэвлэн гаргаж гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.2. Хүндэтгэн үзэх шалтгаанаар бүрдмэл магадлалд хамрагдаагүй даатгуулагч (иргэн)-ийг Төв комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт тухайн иргэн гадаад оронд эмчлүүлж байгаа, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй эсхүл байнга хэвтэрт байдгийн улмаас биечлэн ирж чадахгүй болсныг ойлгоно.
- 5.3. Бүрдмэл магадлалаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлагдсан даатгуулагч (иргэн)-д тухайн оношоор дахин хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох асуудлыг Төв комиссын Мэдрэл, Гэмтэл, Сэтгэц, Чих хамар хоолой, Дотрын шинжээч эмч болон Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 5.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах Төв комисс нь бүрдмэл магадлалд хамрагдаагүй даатгуулагч (иргэн)-ийн тахир дутуугийн тэтгэврийг түр түдгэлзүүлэх талаар орон нутгийн комисст мэдэгдэл хүргүүлнэ.
- 5.5. Бүрдмэл магадлалыг зохион байгуулсан тухай тайланг Газрын зөвлөлөөр хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг Төв комисс биелүүлж ажиллана.

6. Бусад зүйл

- 6.1. Бүрдмэл магадлалын бүрэлдэхүүнд орох төрөлжсөн мэргэжлийн эмчийн нэрсийг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч зөвшилцсөний үндсэн дээр томилон холбогдох албан газарт 21 хоногийн өмнө бичгээр илгээнэ.
- 6.2. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл нь бүрдмэл магадлалын бүрэлдэхүүнд ажиллахаар томилогдсон эмч мэргэжилтэнд зайлшгүй шаардлага гарч өөрчлөх тохиолдолд бүрдмэл магадлал хийх хугацаанаас 10 хоногийн өмнө орлох эмч мэргэжилтний нэрсийг Төв комисст ирүүлнэ.

